

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛ



2025.04.25

АГУУЛГА

Х3	ХУРЛЫН ЗАР
Х5	ХУРЛЫН ХӨТӨЛБӨР
Х6	ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ
Х7	ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН
Х7	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, ТАНИЛЦАХ ЖУРАМ
Х8	ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД
Х9	САНАЛ АВАХ САНАЛЫН ХУУДАС

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 12 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

- Компанийн оноосон нэр, хаяг:** “Худалдаа, хөгжлийн банк” ХК
Улаанбаатар хот, 14210, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа, хөгжлийн банкны төв байр
- Хурал хуралдах газар, өдөр, цаг:** 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 09 цаг 00 минутад
Худалдаа, хөгжлийн банкны боловсруулсан цахим хуудас болох investor.tdbm.mn-ээр дамжуулан цахим буюу зайны технологи ашиглан хуралдуулах.
- Хуралд оролцох хэлбэр:** Цахим /зайнаас/
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:**
2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр
- Хурлаар хэлэлцэх асуудал:**
 - Танилцуулах асуудал:
 - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан;
 - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
 - Ногдол ашиг хуваарилах тухайн ТУЗ-ийн шийдвэр.
 - Хэлэлцүүлэх асуудал:
 - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
 - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;
 - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай.
- Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:**
 - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
 - 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын байгууллагын дүгнэлт;
 - Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоол;
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай” тогтоолын төсөл;
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай” тогтоолын төсөл;
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай” тогтоолын төсөл;

ХӨГЖИЛД ХАМТДАА

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас.

7. *Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцах журам:*

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид дараах арга, хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн танилцаж болно. Үүнд:

- Худалдаа, хөгжлийн банкны investor.tdbm.mn цахим хаягт хандан танилцах;
- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандан танилцах;
- Худалдаа, хөгжлийн банкны төв байранд ажлын өдрүүдийн 10:00-17:00 цагийн хооронд Хурал зохион байгуулах комисст хандан танилцах.

8. *Хуралд оролцох, санал өгөх заавар:*

Хувьцаа эзэмшигч Та дараах аргуудын аль нэгээр хуралд оролцож санал өгөх боломжтой. Үүнд:

Цахимаар оролцох:

- Хуралд зайнаас оролцох хувьцаа эзэмшигчид 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 8 цаг 45 минутаас өмнө investor.tdbm.mn цахим хуудаст хандан зааврын дагуу хуралд цахимаар оролцож, саналаа өгнө.

Урьдчилсан санал өгөх:

- Цаасан хэлбэрээр санал өгөх: Саналын хуудсыг 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цаг хүртэл Худалдаа, хөгжлийн банкны төв байранд Тооллогын комисс хүлээн авна.
- Цахим хэлбэрээр санал өгөх: Худалдаа, хөгжлийн банкны investor.tdbm.mn цахим хуудсанд хандан 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цаг хүртэл саналаа өгөх боломжтой.

9. *Хурал зохион байгуулах болон Тооллогын комисстэй холбоо барих мэдээлэл:*

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 14210, Энхтайваны өргөн чөлөө 19 хаягт орших Худалдаа, хөгжлийн банкны төв байр
Утас: 11 328227

Цахим хаяг: boardoffice@tdbm.mn

Ажиллах цагийн хуваарь: Ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

№	Агуулга	Хугацаа	
1	Хурлын ирцийг бүртгэх	08:30-08:55	
2	Хурлын үйл ажиллагааг эхлүүлэх	09:00-09:02	
3	Хурлын ирц танилцуулах	09:00-09:05	
4	Хурлыг нээх	09:05-09:15	
5	Хэлэлцэх асуудлуудын жагсаалтыг танилцуулах		
6	Хуралд танилцуулах асуудал		
	1	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан	09:15-09:40
	2	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт	
	3	Ногдол ашиг хуваариалах тухайн ТУЗ-ийн шийдвэр	
7	Хурлаар хэлэлцүүлэх асуудал		
	1	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай	09:40-09:55
	2	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах	
	3	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай	
8	Танилцуулга болон хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт, хариулт	09:55-10:05	
9	Тогтоолын төслийн танилцуулга		
	1	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай	10:05-10:15
	2	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай	
	3	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай	
10	Санал хураалт	10:15-10:25	
11	Завсарлага /Санал тооллого/	10:25-10:40	
12	Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулах	10:40-10:45	
13	Хурлын хаалт	10:45-10:50	

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ
TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA
REPRESENTATIVE GOVERNING BOARD RESOLUTION

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10 дахь хэсэг; 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2 дахь хэсэг; 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 65.5, 65.6 дахь хэсэг; 67 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт; Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.2 дахь заалт, 7.4, 7.7, 7.10, 7.11 дэх хэсэг; 8 дугаар зүйлийн 8.11.6 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 09 цаг 00 минутад мэдээллийн технологийн шийдэл (investor.tdbm.mn)-г ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
 - 2.2. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;
 - 2.3. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Зохион байгуулах комиссыг энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Рандолф Коппаг томилсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын Хавсралт 3-ийн дагуу баталж, уг зарыг Монголын хөрөнгийн бирж, Худалдаа, хөгжлийн банкны цахим хуудсаар болон олон

нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор олон нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин олон нийтэд мэдээлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т үүрэг болгосугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг энэхүү тогтоолын Хавсралт 4-ийн дагуу баталж, танилцах боломж нөхцөлөөр хангахыг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т даалгасугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, шийдвэрийн төсөл, саналын хуудас болон тэдгээртэй холбоотой баримт бичгийг 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн дотор Үнэт цаасны компаниудад хэвлэмэл болон цахим байдлаар хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т үүрэг болгосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2025 оны 4 дүгээр сарын 7-ний өдрөөр тогтоосугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэлийн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Монголбанканд хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загварыг энэхүү тогтоолын Хавсралт 5-ын дагуу баталсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг энэхүү тогтоолын Хавсралт 2-т заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд урьдчилан санал хүргүүлж буй Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг 2025 оны 4 дугаар сарын 16-ны өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цаг хүртэл цахим хэлбэрээр болон Худалдаа, хөгжлийн банкны төв байран дээр цаасан хэлбэрээр хүлээн авах, Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын хүлээсэн үүргүүдийг хэрэгжүүлэхийг Тооллогын комисс (Ч.Лхагвасүрэн)-т үүрэг болгосугай.

14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Н.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА

ТООЛЛОГЫН КОМИСС ТОМИЛОХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛЫН ХАВСРАЛТ



Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын тооллогын комисс

Тооллогын комиссын дарга:

Ч.Лхагвасүрэн Дотоод аудитын газрын захирал;

Тооллогын комиссын гишүүд:

Л.Анхбаяр Эрх зүйн боллогын хэлтсийн захирал;
Б.Энхжаргал Тусгай аудитын хэлтсийн ахлах аудитор;
Х.Оюутсэцэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын албаны хуульч.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, ТАНИЛЦАХ ЖУРАМ

1. Хувьцаа эзэмшигч нь дараах баримттай танилцаж болно.

- Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
- 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын байгууллагын дүгнэлт;
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоол;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай” тогтоолын төсөл;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай” тогтоолын төсөл;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай” тогтоолын төсөл;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид дараах арга, хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн танилцаж болно. Үүнд:

- Худалдаа, хөгжлийн банкны investor.tdbm.mn цахим хаягт хандан танилцах;
- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандан танилцах;
- Худалдаа, хөгжлийн банкны төв байранд ажлын өдрүүдийн 10:00-17:00 цагийн хооронд Хурал зохион байгуулах комисст хандан танилцах.

Хурлын талаарх мэдээллийг хурал зохион байгуулах комиссын 11-328227 утас болон boardoffice@tdbm.mn цахим хаягаар ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд холбогдож авна уу.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

___ он ___ сар ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хөт

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа
эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны
өдрийн ээлжит хурлын 01 тоот тогтоолын
хавсралт

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан
дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БОЛОН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр
зүйлийн 29.2.6, 29.2.7 дахь заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.9
дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын
Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Худалдаа, хөгжлийн банкны 2024 оны жилийн үйл ажиллагааны болон аудитлагдсан
санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралтын дагуу баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

РАНДОЛФ КОШЛА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.НЯМСҮРЭН

1. Банкны үйл ажиллагааны талаар төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан
2. Банкны аудитын байгууллагаар баталгаалсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн
удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

___ он ___ сар ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Толоолон удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.8 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.10 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр сонгон томилсугай.

- 1.1. ...;
- 1.2. .../2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс/;
- 1.3. ...

2. Дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр сонгон томилсугай.

- 2.1. ...;
- 2.2. ...;
- 2.3. ...;
- 2.4. ...;
- 2.5. ...;
- 2.6. ...

3. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнөх бүрэлдэхүүний бүрэн эрх дуусгавар болж чөлөөлөгдсөн болохыг дурдсугай.

- 3.1. Жалбагийн Болормаа;
- 3.2. Жамерандоржийн Дэлгэрсайхан;
- 3.3. Загдхүүгийн Нарантуяа /2024 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс/;
- 3.4. Рандолф Коппа;
- 3.5. Должингийн Эрдэнэбилэг;
- 3.6. Дагмидын Янжмаа;
- 3.7. Дамбийжавын Хүрэлбаатар;
- 3.8. Авгааны Энхмэнд;
- 3.9. Дэмчигжавын Отгонбилэг.

4. Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодексе болон бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын дүрэм, журам, заавар, Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад шаардлагатай дүрэм, журам, зааврыг чанд баримтлан ёс зүйтэй, хариуцлагатай ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.НЯМСҮРЭН

___ он ___ сар ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг багтах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.11 дэх заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025-2026 оны буюу дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрийг хүртэлх зардлын төсвийг [] ([.]) төгрөгөөр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.НЯМСҮРЭН

ХӨГЖИЛД ХАМТДАА

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хэсэгтэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЫН САНАЛЫН ХУМАС

Компаний оноосон нэр: “Худалдаа, хөгжлийн банк” ХК
 Компаний хаяг: Улаанбаатар хот, 14210, Сүхбаатар дүүрэг, 19 дүгээр хороо, Худалдаа, хөгжлийн банкны төв байр
 Хурал хуралдах газар, өдөр: 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 9:00 цагт
 Худалдаа, хөгжлийн банкны боловсруулсан цахим хуудас болох investor.ldbm.mn-ээр дамжуулан цахим болон зайны технологи ашиглан хуралдуулах.



Санал өгөх ерөнхий заавар:

- Хувьцаа эзэмшигч нь хурлын бүртгэлийн өдөр буюу 2025 оны 4 дүгээр сарын 7-ний өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор санал өгнө.
- Тэмдэглэгээ хийгээгүй, засварласан, балласан, заруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцоглоно.
- Хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд урьдчилсан санал хүргүүлэхдээ Хувьцаа эзэмшигчийн саналын хуудсыг 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цаг хүртэл хаалбагдох зааврын дагуу investor.ldbm.mn цахим хуудсанд нандан цахим хэлбэрээр эсхүл Худалдаа, хөгжлийн банкны төв байранд насан хэлбэрээр Тоололгын комисст хүргэсэн өгнө.
- Хувьцаа эзэмшигч хувь хүн нь өөр хүнээр төлөөлүүлж бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотаригтаар баталгаажуулж, энэхүү саналын хуудаст хавсаргана.
- Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотаригтаар гэрчлүүлсэн хуульбар, хувьцаа эзэмшигчийн хуралд төлөөлөн оролцох эрх бүхий этгээдийг томилсон шийдвэр (Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол гэх мэт) -ийн эх хувь эсхүл нотаригтаар гэрчлүүлсэн хуульбар, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн иргэний үнэмлэхийн хуульбарыг энэхүү саналын хуудаст хавсаргана.

Хувьцаа эзэмшигчийн эцэг/эхийн нэр, нэр:	
Хувьцаа эзэмшигчийн утасны дугаар:	
Хувьцаа эзэмшигчийн цахим шуудангийн хаяг:	
Регистрийн дугаар:	
Эзэмшиж буй хувьцааны төрөл:	Энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо:	

Санал хураах арга: Ердийн

Ердийн аргаар санал өгөх заавар: Саналын хувилбарыг зөвхөн нэгийг сонгож, оорийн сонгож буй саналын нүдэнд (✓) эсхүл (+) тэмдэг тавина.

№	Хэлэлцэх асуудал	Хувьцаа эзэмшигчийн санал		
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай			
2	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай			

Санал хураах арга: Кумулятив

Кумулятив аргаар санал өгөх заавар:

- Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн 1 (нэг) хувьцаа нь 9 Саналын эрхтэй байна.
- Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

○ **Жишээ нь:** Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүгээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран оорийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурьд харьцаагаар хуваарилсан өгөх эрхтэй.

№	Нэр дэвшигчийн овог, нэр	Кумулятив саналын тоо
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийг сонгох		
1	ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ...-г сонгох тухай	
2	ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ...-г сонгох тухай	
3	ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ...-г сонгох тухай	
Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийг сонгох		
1	ТУЗ-ийн гишүүнээр ...-г сонгох тухай	
2	ТУЗ-ийн гишүүнээр ...-г сонгох тухай	
3	ТУЗ-ийн гишүүнээр ...-г сонгох тухай	
4	ТУЗ-ийн гишүүнээр ...-г сонгох тухай	
5	ТУЗ-ийн гишүүнээр ...-г сонгох тухай	
6	ТУЗ-ийн гишүүнээр ...-г сонгох тухай	

Заварчилгаа:

Хувьцаа эзэмшигч та хувь хүн бол “Хувьцаа эзэмшигч хувь хүн бөглөнө.” хэсэгт, хуулийн этгээдийг төлөөлж оролцож буй бол “Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд бөглөнө.” хэсэгт гарын үсэг зурах шаардлагатайг анхаарна уу.

Хувьцаа эзэмшигч хувь хүн бөглөнө.	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд бөглөнө.
Хувьцаа эзэмшигчийн	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн
Нэр:	Нэр:
Гарын үсэг:	Албан тушаал:
	Гарын үсэг:
2025 оны ...-р сарын ...-ны өдөр	
Тоололгын комисс бөглөх хэсэг:	
Саналын хуудсыг хүтээлгэн авсан өгнөө, цаг:	
Саналын хуудсыг хүтээн авсан Тоололгын комиссын гишүүний нэр, гарын үсэг:	

Саналын хуудсыг хүчингүйд тавиан тоолсон эсэх (доогуур зурах): Тийм Үгүй

Комиссын дарга: / /

Саналын хуудсыг хүчингүйд тавих үндэслэл:

.....

